



ARD

2021  
**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН**

MSE: 

## А Тойм мэдээлэл

- Гүйцэтгэх удирдлагын илгээлт
- Төлөөлөн Удирдах Зөвлөл
- Удирдлагын баг

## А Хувьцаа эзэмшигчид

## А Эдийн засгийн орчин

## А 2021 оны онцлох үйл явдал

## А Гүйцэтгэлийн Тайлан

- Үйл ажиллагааны тайлан
- Эрсдэлийн удирдлага

## А Хөрөнгө оруулалтын багц

## А Хараат бус аудитын тайлан



# Тойм мэдээлэл

# Гүйцэтгэх захирлын илгээлт



Эрхэм хүндэт Ардын хувьцаа эзэмшигч танаа!

Өнгөрч буй 2021 он нь миний хувьд мэргэжлийн амьдралдаа үзсэн, даван туулсан туйлын их савалгаантай, үлэмжийн өндөр өсөлтийг компанийн бүх хэмжээсээр гаргаж чадсан, хамгийн өндөр ачаалалтай, сэтгэл догдлуулсан амжилт бүтээл, алдаа ухаарал дүүрэн жил болж өндөрлөлөө. Эргээд харахад үнэхээр их өөрчлөлтийг бид компани дотроо бий болгосноос гадна хүн ардын хувьд хувьсгалын гэмээр өөрчлөлтийг бид хийж чадсан. Энэ бүхэнд хамтдаа байсан та нартаа юуны түрүүнд талархал илэрхийлэхийг зөвшөөрнө үү?

Ковид-19 цар тахлын хөл хорио, төр засгаас авч хэрэгжүүлсэн бусад онцгой арга хэмжээ, олон улсын хил хязгаарлалтаас үүссэн аялал жуулчлал, худалдаа наймааны тасалдал, түүнээс улбаалсан нийгэм эдийн засгийн гүн цочрол дунд өрнөсөн 2021 оны Ардын гүйцэтгэлтэй холбоотой гол тавилтууд нь хавьгүй өмнө өрөгдөж эхэлсэн гэдгийг юуны өмнө хэлэх нь зүйтэй байх. Бид 2013 оноос хойш төлөвлөж, Хөрөнгө Оруулагч Үндэстнийг цогцлооё, хөрөнгийн зах зээл, банкны салбарын түйвээлтийг явуулъя, КriptoҮндэстэн болж, 4 дүгээр аж үйлдвэрийн хувьсгалд оролцъё, салбаргүй, дижитал банк больё, Ард Апп, АрдКойн хоёр Хүчтэй бөгөөд Хамтдаа гэх алсын харааг баримталж зорин өрнүүлсэн ажлын үр дүн түрүү жил гарсан гэж харж болох боловч бидний ажлыг огт төсөөлөөгүй байдлаар асар их хурцалж, гүн гүнзгий бөгөөд өргөн нөлөөллийг тэс хөндлөнгөөс бүрдүүлж орж ирсэн, ажлыг хурдасгасан хүчин зүйлс бас их тохиолдов.

Хөл хорио, эдийн засгийг сэргээх гэсэн төр засгийн зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, дэлхий нийтээрээ крипто, NFT, DeFi, блокчэйнээр амьсгалж, биткойны үнэ ханш өссөөр хамгийн дээд түвшиндээ хүрч, бид Монголчууддаа Монгол ТВ-тэй хамтран Аппрентис Шоуг хүргэх мөчид өмнөх 5 жилд бий болсон АрдКойн, АрдАппын хэрэглэгчдэд Digital Assets Exchange буюу DAX-ыг амжилттай нэвтрүүлж, танилцуулсан явдлууд нь АрдКойны үнийн хөөрөлт, Ардтай холбоотой хувьцааны өсөлтөнд тодорхой хэмжээнд нөлөөлснийг бид юуны түрүүнд хүлээн зөвшөөрөх ёстой. Гэхдээ бидний Монголчууд чаддаг байсан, чадах болно гэдэг итгэл үнэмшлээрээ, хэлж, уриалсан, түүнийхээ дагуу хийж бүтээсэн бүх бэлтгэл ажил босгосон суурин дээрээ үр дүнгээ өглөө.

# Гүйцэтгэх захирлын илгээлт

---

Монголын хөрөнгийн захын гол үзүүлэлт болж ирсэн ТОП-20 индексн хувьд 130 хувиар өсч, Блүүмберг дэлхийн номер нэг зах зээлээр Монголыг өргөмжилсөн сайхан мэдээтэй хуучин оноо үдсэнд бид бие биедээ баяр хүргэх ёстой болов уу!? Учир нь энэхүү үзүүлэлтийг бүрдүүлсэн гол хүчин зүйл нь та бидний хамтын ажиллагаа байсан гэдэгтэй хэн ч маргахгүй байх. Ардын гэх тодотголтой бүх хувьцаа 2021 онд Монголын Хөрөнгийн Биржийн хамгийн өндөр өсөлттэй байснаас гадна нийт хувьцааны арилжааны дийлэнх хувийг эзэлсэн байдаг. Ингэснээрээ хөрөнгийн зах зээл рүү иргэдийг өргөнөөр татаж, үлэмж их хэмжээний мөнгөний урсгалыг бий болгож, бусад компанийн хувьцааны үнэ ханшинд эерэг өөрчлөлт гаргах үндэс суурийг нь бид хамтдаа тавьсан болно.

Бид 2017 онд КriptoҮндэстэн болох уриалгыг та бүхэндээ хүргүүлж байсан бол Монгол Улс 2020 онд ФАТФ-ын саарал жагсаалтаас гарч, 2021 онд мөн л тэдний зөвлөмжийн дагуу өөрийн Виртуал Хөрөнгийн Үйлчилгээ Үзүүлэгчийн тухай хуультай болж чадлаа. АрдКойноор эхэлсэн крипто шуурга Монголыг нэг мөсөн нөмөрч, бид блокчэйн технологи, криптовалютын тухай мэдлэг, хуримтлуулсан туршлага, хүн амын дундах нэвтрэлтээрээ дэлхийд тэргүүлж эхэллээ. Мэдээжийн хэрэг алдсан зүйлс ч байсан. Цаашид ч энэ их олон койн, биржүүд хумигдах нь жам ёс. Зарим иргэд ч санхүүгийн хувьд хохирохыг үгүйсгэхгүй. Гэхдээ том зургаараа бид блокчэйн, криптогийн хувьсгалыг Монголдоо хийж чадлаа гэж бодож байна. Үүнийг улс орны ирээдүйд сайн зүйл гэж харж байгаа – 4 дүгээр аж үйлдвэрийн хувьсгалд Монголчууд бид бүрэн дүүрэн оролцож алхаж чадлаа. Үүнийг АрдКойн манлайлж ирсэн бөгөөд цаашид өөрийн экосистемээ улам бүр төгөлдөршүүлэх онцгой байр суурин дээр очиж чадсан гэж дүгнэж байна. Кripto өвөл айсуу гэж хүмүүс ярьж байгаа нь оргүй зүйл биш бөгөөд АрдКойны үнийн хувьд сайхан засвар, тохируулга орон цаашдын зам дардан боллоо гэж би олзуурхаж байгаа.

Хөрөнгө Оруулагч Үндэстнийг цогцлоох бидний эрхэм зорилгын хүрээнд бид экосистемээ улам бүр төгөлдөршүүлэх чиглэлд хэд хэдэн том алхмуудыг хийлээ. Тэдний эхэнд мэдээжийн хэрэг 2015 онд үүсгэн байгуулагдаад үйл ажиллагаа нь жигдэрч чадаагүй байсан Монголын Үнэт Цаасны Биржид шинээр хөрөнгө оруулж, Улаанбаатарын Үнэт Цаасны Бирж буюу UBХ гэх шинэ нэр, брэндийн дор ажлыг нь эхлүүлж чадсан явдал орно. 2022 онд бид энэхүү биржид бусад мэргэжлийн тоглогчдыг хөрөнгө оруулагчаар оруулж ирэх, үйл ажиллагааг нь өргөжүүлэх чиглэлд ихээхэн ахиц дэвшил гаргахаар ажиллаж байна. Та бүхэнд олон жилийн турш нуршсан Чоно Эдийн Засгийн суурийг бид цутгасаар байгаа гэдгийг та олж харж байгаа байх. Бид Зорилготой, Зоригтой, Зогсолтгүй зүтгүүлсээр байгаа.

Ард олон жилийн турш хамтран ажиллаж ирсэн Грэйп Сити Монгол, Мост Финтек хоёрт стратегийн хөрөнгө оруулалт хийж, тэдгээр компанийг цаашид олон нийтийнх болгох төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэллээ. Эдгээр компаниуд нь бидний өнөөг хүртэл барьж ирсэн технологи дээр суурилсан санхүүгийн салбарын түйвээлтийг хийх, цаашид олон улсад тэлэх зорилгын хүрээнд хамтарч байгаа юм. Бид банк, санхүүгийн салбарын бүх тоглогчдод Ардтай мөр зэрэгцэж эдгээр компаниудад хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллахыг уриалж эхлээд байгаа. Та ч гэсэн энэ талаар сонирхвол бидэнтэй холбогдохыг урьж байна.

# Гүйцэтгэх захирлын илгээлт

---

2017 онд байгуулагдсан Монголын анхны криптовалютын багцад хөрөнгө оруулалт хийх зорилготой КriptoҮндэстэн ХХК Монголын Хөрөнгийн Бирж дээр BUN тикер дор арилжаалагддаг Булган Ундрага ХК-тай нэгдсэнээр BUN үнэ оны эхнээс 760 төгрөгөөс 200 мянга хүртэл өсөв. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээл дээрх түүхэн хамгийн өндөр өсөлт болов. BUN нийт үнэлгээ 18 тэрбум төгрөг болсон ба Ард түүний 67 хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг бөгөөд бид энэхүү компанийн засаглал, удирдлагыг сайжруулах, олон түмэнд хандсан маркетингийн ажлыг 2022 оноос илүү идэвхжүүлэх болно. Энэ компанийн хувьцаагаар дамжуулж хувь иргэд, аж ахуйн нэгжүүд криптовалютын шууд савлагаанаас хамгаалагдаж, тулхтай хөрөнгө оруулалт хийх үүдийг бид Монголдоо анхлан нээсэн нь энэ.

Монголын санхүүгийн салбарын хувьд ч, Ард Санхүүгийн Нэгдлийн хувьд ч 2021 онд хамгийн том нөлөөллийг авчирсан гол тоглогч бол мэдээжийн хэрэг DAX байсан. Оргил үедээ нийт хагас сая хүн анх удаагаа крипто арилжаанд оролцож, АрдКойны үнэ ханшийг хагас жилийн дотор 450 дахин өсгөж чадсан нь Монголд крипто шуургыг эхлүүлж, 2 их наяд төгрөгийн арилжаа явагдах боломжтой гэдгийг харуулж, араасаа 20-30 бирж гарах, 50-70 койн мэндлэх боломжийг бий болгосон нь энэхүү биржийн гавьяа гэдэгтэй маргах хүн үгүй байх. Ард Аппын хэрэглэгчдэд шууд оролцох боломжийг бий болгосноороо бидний энэ амжилт анх тодорхойлогдсон бол технологийн асуудлаас болж бид өөр шийдэл олж хайхаас аргагүй болсон юм.

Цаашид DAX-ын хувьд эргээд Ард Апптайгаа нягт уялдах, олон улсын түвшинд гарах ажлууд хүлээгдэж байна. Энэ чиглэлд бид хөрөнгө оруулалт хийж, IDAX биржийн үйл ажиллагааг оны эцсээр эхлүүлсэн юм. Цаашид АрдКойноор шимтгэлээ төлөх, урамшуулал авах, арилжааны тэмцээнд оролцох боломжийг бид нээж ажиллахаас гадна олон улсад үйл ажиллагаагаа нэвтрүүлж эхлэхээр зэхэж байна.

# Гүйцэтгэх захирлын илгээлт

---

Бид DAX дээр секюрити токены арилжааг туршиж, Монголын анхны стэйблкойн болох MONT-ыг нэвтрүүлсэн юм. Харин АрдМааний нь бидний хувьд төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоо руу нэвтрэх анхны оролдлого болсон бөгөөд 2022 оны туршид бид энэ төслийн ажлын явц, үр дүнг тухай бүр танилцуулан ажиллах болно. Түүнчлэн бид Metaverse, NFT-гийн зах зээл рүү мөн гүн гүнзгий нэвтэрч оролцож эхлээд байна.

Салбаргүй байдлаар банк санхүүгийн бүхий л үйлчилгээг нэг дороос авах боломжийг олгох зорилготой 5 жилийн өмнөөс зах зээл дээр нэвтэрч ирсэн Ард Аппын 4 дэх хувилбарыг нэвтрүүлж, нэг сая хэрэглэгчийг татсан амжилтыг бид өнгөрсөн онд гаргалаа. Үүнийгээ дагаад манай компаниудын борлуулалт нэмэгдэж, ашигт ажиллагаанд сайнаар нөлөөлөв. Манай тэтгэврийн данс эзэмшигчдийн тоо 100 мянгыг давж, Ард Активын хөрөнгө 30 тэрбумд хүрсэн бол Монголын Хөрөнгийн Бирж дээр явагдсан хоёрдогч арилжааны дийлэнх хувь Ард Аппаар хийгдэв. Бид 25 мянган хүүхдэд АрдКидс Аппаа танилцуулж чадлаа.

Хувьцаагаа олон түмэнд түгээх үндсэн зорилгын хүрээнд 4 удаагийн хөрөнгө оруулалтын аян болон Хувьцаатай хүүхэд, Илгээлтийн эзэд, Цахим үндэстэн арга хэмжээгээр нийт 15,560 хөрөнгө оруулагчдад AARD 7.5 хувь, AIC 5.2 хувь, ADB 4.8 хувь болон TNGR, MNP, ХОС-ын тодорхой хувиудыг нийт 13 тэрбум төгрөгөөр борлуулав. Үүний хажуугаар үнэ нь тохироод сул эх үүсвэр байсан тохиолдолд зарим хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эргүүлж авах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн бөгөөд нэгдлийн хэмжээнд 37.9 тэрбум төгрөгөөр AARD, 1.5 тэрбум төгрөгөөр AIC, 1.6 тэрбум төгрөгөөр ADB хувьцааг эргүүлэн худалдан авсан юм.

Мэдээжийн хэрэг дээр дурдсанчлан хүндрэл бэрхшээл, алдаа дутагдал ч их тохиолдов. Бидний төсөөлж чадаагүй өндөр ачааллын улмаас платформ, апп, вэбсайтууд маань гацах, хэрэглэгчдийг чирэгдүүлэх явдал их гарсанд бид хүлцэл өчье. Манай багийнхан галыг унтраах хариу үйлдэл хийх, яаралтай арга хэмжээг өдөр шөнөгүй авч ажилласан ч тэр болгон амжилттай байгаагүйг онцлох хэрэгтэй юм. Бид техник технологийг сайжруулах чиглэлд хөрөнгө оруулалтыг тухай бүр хийсэн бөгөөд харилцагч, хэрэглэгчийн үйлчилгээг төгөлдөршүүлэхээр тусдаа бие даасан Харилцагчийн үйлчилгээний төвийг байгуулж ажиллууллаа.

Ардын хөрөнгө оруулалттай компаниудын нийт ажилчдын тоо 1,800 гаруй болсон бол шууд удирдлаган доорх ажилчдын тоо 60 хувь буюу 100 гаруй хүнээр тэлэв. Ардын хуучин оффисыг ТэнГэр ТВ болон Unread Media-д зайчилж өгөөд Ардын бусад бүх компаниуд Сэнтрал Тауэр рүү нүүж орлоо. Харин манай харилцагчийн үйлчилгээний цахим төв маань Сансарт байрлах шинэ байранд орсон юм.

Энэхүү шилжилтийн үеийг ашиглаж цахимаар харилцагчийн мөнгө хөрөнгийг луйвардах, хулгай хийх явдал ч гарч байсныг бид дурдах ёстой. Энэ тал дээр бид технологийн түншүүдтэйгээ нягт холбоотой ажиллаж, хууль хүчний байгууллагуудаар асуудлыг шалгуулж байна.

# Гүйцэтгэх захирлын илгээлт

---

Бид Богд банкинд хөрөнгө оруулах асуудлаар 8 сар хөөцөлдсөний эцэст татгалзахаас өөр гарцгүй болсон бол Канадын хөрөнгийн зах дээр гарах судалгааны ажил төдийлөн нааштай эерэг үр дүн авчраагүй юм.

Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороонд гаргасан зөвшөөрлийн хүсэлт овоорч, бидний асуудлыг хойш нь тавьж, цааргалсан байдлаас болж бид зах зээл дээрх олон боломжийг алдсаар байгааг энд цохон тэмдэглэе.

Бидний хамгийн ихээр харж хүлээж байсан хоёр хуулийн санаачлагын хувьд амин чухал Виртуал Хөрөнгийн Үйлчилгээг Үзүүлэгчийн тухай хууль УИХ-аар батлагдаж, харин Хувийн тэтгэврийн хууль тодорхой бус байдалтай үлдэв.

Маркетингийн хувьд Аппрентис Шоуны үр нөлөө үлэмж ихээр мэдрэгдсэн бөгөөд ялагч болох Бархас манайд Маркетингийн ажлыг ахалж ажиллаж эхэлснийг дурдахад таатай байна. Бид Цахим Үндэстэн арга хэмжээний гол спонсорор ажиллаж, Альфа Урамшууллыг улс даяар зарлалаа. Ард Лизингийн хувьд Өсдөг Машин хөтөлбөрийг эхлүүлсэн бол Илгээлтийн Эзэд Аяныг хөдөө орон нутагт өрнүүлж, Ардын Брокерыг идэвхжүүлэв.

Эхэндээ дурдсанаар миний мэргэжлийн амьдралд тохиолдсон хамгийн, хамгийн жил бол яах ч аргагүй 2021 он байв. Харин одоо Крипто өвөл хаяанд ирээд байна гэж харж байна. Яг л 2017 оны өвөл шиг. Тийм ч учраас Аваад март. АвДартаа хийгээд орхи гэдэг үг улам бүр хүчтэй нөлөөтэй байх болно. Энэ өвлийг давсан хүмүүс хожих болно. Ялагч болно. Энэ үйл явдал миний итгэх Азийн Чоно Эдийн Засаг болох мөрөөдөлд том ахиц гаргах юм.

2022 онд явагдах банк санхүүгийн салбарын шинэчлэл, түйвээлтэд идэвхтэй байр сууринаас оролцох болно. Нэгдэх, нийлэх үйл явцыг идэвхийлэн эрэлхийлэх болно.

СКОПА төсөл хөдөлснийг өнөөдөр би та бүхэндээ дэлгэж байна - бид банкны үйл ажиллагааг илүү өргөн хүрээтэй, хамгийн гол нь хүндээ хүртээмжтэй, шударга болгож, Монголын эдийн засгийн бүтээмжийг үүгээрээ дээшлүүлэх боломжтой гэж харж байгаа.

Бид том зорилго хамтдаа дэвшүүлээд түүнийгээ гүйцэлдүүлэх үйл явцыг зогсолтгүй авч явсаар ирсэн. Урам зориг нэмдэг та бүхэндээ сайн сайхныг хүсэн ерөөе!

Гүнээ хүндэтгэн мэхийн ёсолсон,  
Таны хувь эзэмшдэг Ардын захирал  
Хутагт овогтой Чулууны Ганхуяг



# Ард Санхүүгийн Нэгдэл

---

## Эрхэм зорилго

Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлооно

## Алсын хараа

Бүс нутагтаа тэргүүлэгч финтек нэгдэл болох



Финтек банк




Тогтвортой өсөлт



Цогц шийдэл



Хөрөнгө Оруулагч  
Үндэстэн



Бүтээлч түйвээлт

---

Дижитал шилжилт

Хүчтэй. Хамтдаа.

Салбаргүй банк

Давхар бүртгэл

Олон улсад гарах

---

# Компанийн тухай

---

Анх 2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон АНУ-ын Мэрси Кор төрийн бус байгууллага ХасБанкны нийт ажиллагсдад зориулан 600 сая төгрөгийг ажиллагсдын хувьцаа эзэмшүүлэх санд хандивлах шийдвэрийг гаргасан юм.

Улмаар ХасБанкны ажиллагсад тус сангаас олгогдсон хувьцааны үнэ цэнийг өсгөх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх зорилгоор өөрийн хувьцаагаа ХасБанкны толгой компани болох ХАС-ГЭ ХХК-ийн хувьцаагаар солих байдлаар хөрөнгө оруулалт хийсэн болно.

ХАС-ГЭ ХХК нь тухайн үеийн удирдлагын шийдвэрийн дагуу ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болж өөрчлөгдсөн бөгөөд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг томоохон компаниудын нэгдэл болж өргөжсөн юм.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь ХасБанкны үүсгэн байгуулагч, одоогийн Гүйцэтгэх Захирал Ч.Ганхуягийн санаачилгаар 2005 оны 9 сард Employee Investment Trust буюу И Ай Ти ХХК нэртэйгээр байгуулагдсан бөгөөд Монголын анхдагч институционал хөрөнгө оруулагчийн үндэс суурь ийнхүү тавигдсан түүхтэй.

И Ай Ти нь үүсгэн байгуулагдах үедээ нийт 1.2 сая төгрөгийн дүрмийн сантай, 10 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 12,000 гаруй хувьцаа эзэмшигчтэй, 80 орчим тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болж өргөжсөн байна.

2013 онд манай гол хувьцаа эзэмшигчид шинэ стратегийн зорилгоо тодорхойлж, Ард Санхүүгийн Нэгдэл гэх нэрэн дор үйл ажиллагаагаа явуулах түүхэн шийдвэрийг гаргасан юм. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд бид Ард Кредит, Ард Даатгал, Ард Секюритиз, Ард Лайф (МТНД ХХК) болон Ард Активд тасралтгүй хөрөнгө оруулж эхэлсэн билээ. 2016 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр болсон томоохон хувьчлалд амжилттай оролцож Монгол Шуудан ХК-ийн гол хөрөнгө оруулагч болж чадсан юм. 2017 онд манай үндсэн хөрөнгө оруулалтын багцад хөрөнгө оруулалтын сангийн удирдлагыг хэрэгжүүлэх Ард Менежмент, блокчэйн болон криптовалютын чиглэлээр ажиллах Ард Бит компаниуд нэмэгдсэн байна. 2018 оноос ТэнГэр Системс компани өөрийн үйл ажиллагааны чиглэлд шинэчлэлт хийж, блокчэйн технологи руу шилжиж эхлэв. 2019 онд Ард Пропертиз, Ард Риэл Эстейт, Ард Лизинг, Ард Холдингс Интернэшнл, Ард Бит зэрэг компаниуд байгуулагдаж, нэгдлийн бүтцэд багтаж эхлэв.

Бид хүн бүр бүтээсэн баялгаасаа хувь хүртэх ёстой, харилцагч иргэн бүр банкныхаа эзэн нь байх ёстой гэсэн итгэл үнэмшилдээ хөтлөгдөн 2015 онд Ард Холдингсыг хаалттай хувьцаат компани болгосон билээ. 2017 оны төгсгөлд Хөрөнгө Оруулагч Үндэстэн Жинст-Увс нээлттэй ХК-тай урвуу хэлбэрээр нэгдэж Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдаж эхэлсэн бол 2019 оны 8 сарын 8-нд Ард Санхүүгийн Нэгдэл RTO хийснээр нээлттэй хувьцаат компани болсон юм. 2020 онд Монголын анхны хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэстний Хувьчлалын Сан үйл ажиллагаагаа амжилттай явуулж эхэлсэн бол Виртуал Хөрөнгийн Бирж болох DAX мөн онд олон түмэнд үйлчилгээгээ хүргэж эхлэв.

# Төлөөлөн удирдах зөвлөл

## Ердийн гишүүд



Чулуун **Ганхуяг**  
Гүйцэтгэх захирал,  
Ард Санхүүгийн Нэгдэл



**Бруно** Рашле  
Дэд ерөнхийлөгч,  
Шродер Адвек



Авир **Сүхдорж**  
Үүсгэн байгуулагч,  
ГрэйпСити Монгол, МОСТ Финтек



Одончимэд **Одбаяр**  
ТУЗ-ийн гишүүн,  
Ард Даатгал

## ТУЗ-ийн дарга



Пүрэвжаргал **Батбаяр**  
ТУЗ-ийн дарга,  
Ард Санхүүгийн Нэгдэл

## Хараат бус гишүүд



Мөнх-Очир **Сэргэлэн**  
Захирал,  
Монгол Коосэн Технологийн Коллеж



Чулуун **Мөнхбат**  
Ерөнхийлөгч,  
СаусГоби Сэндс



**Михаил** Зелдович  
Хяналтын зөвлөлийн дарга,  
Кокүүн Капитал



**Арно** Вентура  
Удирдах партнер,  
Гожо Компани

# Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ-ийн үйл ажиллагаа

2021

## ТУЗ-ийн хурал

Ээлжит хурал

4

Ээлжит бус хурал

3

## Хороодын хурал

Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороо

7

Аудитын хороо

8

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

8

## Бусад

Хэлэлцсэн асуудал

66

Гаргасан шийдвэр

41



# Удирдлагын баг



Чулууны **ГАНХУЯГ**  
**Гүйцэтгэх Захирал**

Унгарын Будапешт хотын  
Корвинус Эдийн Засгийн их сургууль  
Санхүүч



Жаргалангийн **АЛТАНГҮНИЙ**  
**Төр Засаг, Өлөн Нийтийн Хэрилцаа**  
**Эрхэлсэн Захирал**

Тайваны Үндэсний  
Шинжлэх Ухааны их сургууль  
Бизнесийн удирдлагын мастер



Батбилэгийн **ЗОЛБОО**  
**Санхүү Эрхэлсэн Захирал**

АНУ-ын Нью-Йорк  
Мужийн их сургууль  
Санхүүч



Энхсайханы **АМАРБАЯСГАЛАН**  
**Хөрөнгө Оруулалтын Тэргүүн Банкир**

АНУ-ын Индиана их сургууль  
Бизнесийн удирдлагын мастер



Сүхбаатарын **АНАР-ЭРДЭНЭ**  
**Хянан Нийцүүлэлт Эрхэлсэн Захирал**

БНХАУ-ын Бээжингийн их сургуулийн  
Хууль зүйн сургууль  
Эрх зүйч



Мөнхбатын **МӨНХ-ЭРДЭНЭ**  
**Дотоод Аудитор**

Мандах-Бүртгэл их сургууль  
Аудитор, Мэргэшсэн нягтлан  
бодогч



Цолмонгийн **Бархас**  
**Маркетинг Эрхэлсэн Захирал**

Ард Холдингс Интернэшнл ХХК-ийн  
**Гүйцэтгэх Захирал**

АНУ-ын Виржиниагийн Олон Улсын  
их сургууль  
Бизнесийн удирдлага



Баярсайханы **ОЮУТЦЭЦЭН, АССА**  
**Эрсдэл Эрхэлсэн Захирал**

Их Британийн Лондон хотын  
ВРР их сургууль Санхүү, нягтлан бодох  
бүртгэлийн мастер



Эрдэнэбат **БАЯРМАГНАЙ**  
**Технологи Эрхэлсэн Захирал**

Жежү Үндэсний Их сургууль  
Компьютер программ хангамжийн  
инженер



# Хувьцаа эзэмшигчид

# Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

#	Хувьцаа эзэмшигч	2020	%	Өөрчлөлт		2021	%
1	И Ай Ти	733,349	2.6%	2,459,062	8.6%	3,192,411	11.2%
2	DAX (ARDT)	1,000,000	3.5%	1,413,592	4.9%	2,413,592	8.4%
3	Бруно Рашле	2,098,592	7.3%	6,000	0.0%	2,104,592	7.4%
4	А.Сүхдорж	563,155	2.0%	1,304,222	4.6%	1,867,377	6.5%
5	Ардын Тэтгэврийн Данс	1,565,288	5.5%	153,659	0.5%	1,718,947	6.0%
6	Ард Холдингс Интернешнл	2,874,410	10.0%	(1,403,991)	(4.9%)	1,470,419	5.1%
7	Г.Уянга	1,333,147	4.7%	48,789	0.2%	1,381,936	4.8%
8	Ч.Ганхуяг	1,264,519	4.4%	103,745	0.4%	1,368,264	4.8%
9	Ард Секюритиз	1,033,080	3.6%	(419,127)	(1.5%)	613,953	2.1%
10	Ард Лизинг		0.0%	603,571	2.1%	603,571	2.1%
11	Н.Мөнхнасан		0.0%	603,401	2.1%	603,401	2.1%
12	Ронок Лимитед	479,111	1.7%	0	0.0%	479,111	1.7%
13	С.Гэрэлтуяа	455,717	1.6%	218	0.0%	455,935	1.6%
14	Ард Даатгал	417,905	1.5%	(6,450)	(0.0%)	411,455	1.4%
15	С.Оргил	0	0.0%	383,800	1.3%	383,800	1.3%
<b>Топ 15 хувьцаа эзэмшигчид</b>		<b>13,818,273</b>	<b>48.3%</b>	<b>5,250,491</b>	<b>18.3%</b>	<b>19,068,764</b>	<b>66.6%</b>
Бусад хувьцаа эзэмшигчид		12,138,776	42.4%	(2,593,277)	(9.1%)	9,545,499	33.4%
Эргэлтэд буй хувьцаа		28,614,263	100.0%			28,614,263	100.0%
<b>Хувьцаа эзэмшигчдийн тоо</b>		<b>4,779</b>		<b>14,255</b>		<b>19,034</b>	
<b>ARDT эзэмшигчдийн тоо</b>				<b>6,591</b>		<b>6,591</b>	

# ТУЗ-ийн гишүүдийн эзэмшиж буй хувьцаа

#	ТУЗ-ийн гишүүд	AIC		AARD		ADB		BUN		TNGR	
		2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
1	Чулуун Ганхуяг	9,561	57,019	1,264,519	1,368,205	714,785	887,885		3072		2,133
2	Пүрэвжаргал Батбаяр	70,586	40,008	88,008	90,728				129		
3	Бруно Рашле	25,591	25,591	2,098,592	2,104,592						
4	Мөнх-Очир Сэргэлэн	17,407	945	56,432	62,335				1		
5	Одончимэд Одбаяр				7,091				1		
6	Авир Сүхдорж	149,749	203,994	563,155	1,226,377	5,086,580	5,086,580		1		
7	Чулуун Мөнхбат	16,342	16,342	29,686	36,786						
8	Михаил Зелдович										
9	Арно Вентура					39,682					



# Ногдол ашиг

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2021 оны 4 сарын 30**-ны өдөр **live.ard.mn** цахим хуудсаар амжилттай зохион байгуулсан.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 3-р сарын 19-ний эчнээ санал хураалтаар хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2021 оны 4 сарын 12**-ны өдрөөр тогтоосон. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн нийт гаргасан хувьцааны **28,614,263** ширхэг хувьцаанаас саналын эрхгүй охин болон хараат компанийн эзэмшиж буй 9,119,529 ширхэг энгийн хувьцаа байсан. Үүнээс саналын эрхтэй 19,494,734 ширхэг энгийн хувьцаанаас саналын эрхтэй 12,729,301 ширхэг буюу **65.3** хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид ХЭХ-даа идэвхтэй оролцов.

ХЭХ-аар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлав. ТУЗ-ийн ердийн гишүүнээр Ч.Ганхуяг, А.Сүхдорж, Бруно Рашле, О.Одбаяр нар сонгогдов. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр П.Батбаяр, М.Сэргэлэн, Ч.Мөнхбат, Михаил Зелдович, Арно Вентура нар сонгогдов.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 2-р сарын 5-ны ээлжит бус хурлаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын өгөөжөө ихэсгэх зорилгоор 2020 оны санхүүгийн жилд компанийн хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.



# Эдийн засгийн орчин

# Эдийн засгийн орчин

---

2008 оны санхүүгийн их хямралын дараах урт хугацаанд үргэлжилсэн дэлхийн эдийн засгийн өсөлт нь COVID-19 цар тахлын дэгдэлтээс болж 2020 оны эхнээс зогссон. Хөл хорио, өвчин эмгэг, нас баралт нь эдийн засагт асар их зардал үүсгэж, дэлхийн хоёр дугаар дайнаас хойшхи хамгийн том эдийн засгийн уналтыг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч COVID-19 цар тахлын хоёр дахь жилд буюу 2021 онд тэнцвэргүй, тодорхойгүй байдалд хүргэсэн эрсдэл их байсан ч дэлхийн эдийн засаг сэргэж эхэлсэн. 2020 онд -3.1 хувийн уналттай байсан бол 2021 онд 5.9 хувийн өсөлтийг бүрдүүлсэн байна.

Цар тахал эхэлснээс хойш улс орнууд эдийн засгаа дэмжих зорилгоор төсөв, мөнгөний бодлогод нэг төрлийн хандлагыг баримталж байсан ч энэ арга нь үр дүнтэй байсангүй, харин дэлхийн зарим хэсэгт санхүүгийн хямрал, ажилгүйдлийг гүнзгийрүүлэх бас нэгэн хүчин зүйл болсон. Шинэ төрлийн коронавирус хувьсан өөрчлөгдөж байгаа тул дархлаажуулалтын явц, хувь хэмжээ, хүртээмжийн байдал нь бодлого боловсруулагчдад хүндрэл учруулсан. Зарим улс орнууд хилээ нээж, олон улсын худалдаа сэргэж байгаа ч дархлаажуулалтын түвшин бага, вакцины хүртээмж хязгаарлагдмал орнуудын хил хаалттай байгаа нь борлуулалтын гинжин хэлхээг түгжсэн хэвээр байна.


Ингэснээр 2021 оны хоёрдугаар хагаст эдийн засгийн олон салбарт инфляцийн өсөлт ажиглагдсан. Хөл хорионы дараа дэлхий даяаар бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсэн ч улс орнуудын хилийн хаалт, хоригоос үүссэн нийлүүлэлтийн хүндрэлээс болж эцсийн хэрэглэгч дээр очиж буй үнэ өндөр хурдтай өссөөр байна. Хэрэв энэхүү хандлага үргэлжилбэл инфляцийн өсөлт нь эдийн засгийн сэргэлтийг дарж болзошгүй.

Монгол Улс 2020 онд нийт 146 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт эргэлт 12.9 тэрбум доллар, үүнээс экспорт 7.6 тэрбум доллар, импорт 5.3 тэрбум доллар боллоо. Худалдааны нийт эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үес 876.9 сая доллар буюу 6.4 хувиар, экспорт 43.3 сая доллар буюу 0.6 хувиар, импорт 833.6 сая доллар буюу 13.6 хувиар тус тус буурчээ. Гадаад худалдааны тэнцэл 2019 онд 1.5 тэрбум долларын ашигтай гарсан бол 2020 онд өмнөх оноос 790.3 сая доллароор нэмэгдэж, 2.3 тэрбум долларын ашигтай байна.

# Олон Улсын Санхүүгийн Корпорацийн дэлхийн ДНБ-ийн зураглал

IMF DataMapper

Real GDP growth (Annual percent change, 2021)




©IMF, 2021, Source: World Economic Outlook (October 2021)

2020 онд Монголын эдийн засаг сүүлийн 10 жилд байгаагүй гүн хямралд орж ДНБ 5.3 хувиар унасан ч 2021 онд 1.4 хувь болж сэргэлээ. Засгийн газар "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх арван их наядын цогц төлөвлөгөө"-г баталж, эдийн засгаа дэмжих арга хэмжээ үргэлжлүүлэн авсан бөгөөд жилийн хугацаанд бодлогын хүүг хэвээр хадгалсан.

2021 онд төсвийн алдагдал өмнөх онтой харьцуулбал 35.9 хувиар буурч, 2.9 их наяд төгрөг болсон. Улсын төсвийн нийт орлого, тусламж өмнөх оноос 3.8 их наяд буюу 36.5 хувиар өсч 14.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 12.7 их наяд болж өссөн бол Засгийн газрын зарлага, эргэн төлөгдөх цэвэр өр 12 хувиар өсч 15.6 их наяд төгрөгт хүрчээ. Мөн хил нээгдсэн хэдий ч түүхий нефтийн үнэ нэмэгдэж, хөрш улс орны хил хаагдсаны улмаас тээвэрлэлт удааширч, тээвэрлэлтийн зардал нэмэгдсэн нь инфляци 13.4 хувьд хүрхэд голчлон нөлөөлсөн.


# Макро эдийн засаг

## ДНБ өсөлт\*




- Бодит ДНБ
- - Монголбанкны таамаг
- - Дэлхийн банкны таамаг (2022 оны 1 сар)

## Инфляц




## Бодлогын хүү





# 2021 оны онцлох үйл явдал

# Үйл ажиллагааны тайлан



# Маркетинг

Ард Ток Шоу

Ардын Альфа урамшуулал

Ард Ток Шоу

Телеграм мялаалга

ARDM  
Эйрдроп

“Өсдөг машин” хөтөлбөр

Аппрентис Монгол

Хүүхэд бүрт 77 АрдКойн

АрдШоп, Ардын Тэтгэврийн Данс АрдКойны зах

Kids with StoXX

Road21K #АвДар

1 сар

2 сар

3 сар

4 сар

5 сар

6 сар

7 сар

8 сар

9 сар

10 сар

11 сар

12 сар

Сюрприз  
хөтөлбөр

АрдМото  
урамшуул

Digital  
Nation 21

#АмжилтынАрд



Аялал

ХОУ Дархан,  
Эрдэнэт

DAX 1 жилийн ойн  
эйрдроп



# Крипто



100 дээш AARD тэй бол 1 AARD тутамд 1 ARDX



# Гүйцэтгэлийн тайлан

# Гол үзүүлэлт

	2020У4	2021У4	
		Бүрэн эзэмшлийн*	Бүх хөрөнгө оруулалт
Компани	31	34	42
Ажилтан	223	364	1,702
Тусгай зөвшөөрөл	35	35	44
Удирдлагад буй хөрөнгө (сая төгрөг)	213	1,100	1,181

*\*Үүнд ТэнГэрЛиг, Монгол  
Шуудан, ГрэйпСити, Мост  
Мони багтаагүй*

## Хувьцаа эзэмшигчдийн өсөлт

	2020У4	2021У4	Өөрчлөлт	
AARD	4,523	19,034	+14,511	4.2 x
AIC	2,069	10,044	+7,975	4.9 x
ADB	2,139	13,484	+11,345	6.3 x
MNP	1,200	2,830	+1,630	2.4 x
XOC	2,451	7,845	+5,394	3.2 x
BUN	5	2,307	+2,302	461.4 x
ARDT		6,591	+6,591	
TNGR		549	+549	
<b>Нийт</b>	<b>12,387</b>	<b>62,684</b>	<b>+50,297</b>	<b>5.1 x</b>

## Харилцагчдын өсөлт

	2020У4	2021У4	Өөрчлөлт	
Ард Апп хэрэглэгч	637,000	990,071	+353,071	55.4%
АрдКидс хэрэглэгч		22,113	+22,113	
АрдКойн эзэмшигч	286,117	516,425	+230,808	80.5%
Зээлийн данс	37,694	47,303	+9,609	25.5%
Даатгуулагч	166,509	235,470	+68,961	41.4%
Тэтгэврийн хуримтлалын данс	10,447	100,600	+90,153	9.6x
Үнэт цаасны данс	89,305	146,893	+57,588	64.5%
ХЗХ-ны гишүүд	1,062	2,678	+1,616	2.5x

# Хувьцааны арилжаа



		2021		2022			
<b>Нээлт</b>	₮1,699	<b>Хувьцааны эргэлт</b>		33%	5.4%	<b>P/B</b>	<b>1.06</b>
<b>52 долоо хоног</b>	₮1,628 - ₮12,750	<b>Арилжигдсан дүн</b>		₮72.2 тэрбум	₮13.2 тэрбум	<b>P/E</b>	<b>1.4</b>
<b>Хаалт (2021/12/31)</b>	₮9,785	МХБ нийт хувьцааны хоёрдогч арилжааны дүн		₮230.2 тэрбум	₮41 тэрбум	<b>Үнэ/Үнэлгээ</b>	<b>0.64</b>
<b>33Ү</b>	₮280 тэрбум	AARD эзлэх хувь		31.4%	32.1%		

# Хөрөнгө оруулалт ба хэлцлүүд



## Платформ болон мэдээлэл технологийн

1. ГрэйпСити Монгол
2. МОСТ Финтек
3. Дайверс Солюшнс
4. АрдШопд нэмэлт хөрөнгө оруулалт хийв
5. iDAX




## Санхүү

6. UBX (Даац)
7. КриптоҮндэстэн  
MSE: BUN RTO
8. Ард Лайф  
MSE: LIFE RTO
9. Батхишиг хувьцаа буцаан авалт
10. Ард Актив
11. Ардын Тэтгэврийн Данс



## Хэвлэл мэдээлэл

12. ТэнГэрЛиг Медиа Нэгдэл  
MSE: TNGR RTO
13. VTV
14. ОРИ Медиа
15. ОРИ Студиос
16. Монгол ТВ
17. Анрид (Unread)



## Үл хөдлөх

18. Заг бонд
19. Ард Пропертиз
20. Үл хөдлөх худалдан авалт



## Сан

21. ХАСҮ сан

**244 тэрбум  
төгрөг**

# Нийгмийн хариуцлага

## Хандив

Хүүхэд бүрт  
77 АрдКойн

Ид шидийн  
орон

Гадаадад гацсан  
Монголчуудад туслах  
Хүчтэй Хамтдаа төсөл

Эмчилгээний зардлын  
хандив

Цар тахлын үед хамгийн  
эрсдэлтэй бүсэд ажилласан  
сувилагчдад

Монгол Шуудан төв  
салбарын шинэчлэлт

## Боловсрол

Hackateen

Ard Students  
challenge

“Цахим Алт 2” ном

Илгээлтийн эзэд

## Байгал орчин

Тэрбум Мод

## Тэгш оролцоо

No One Left Behind.  
Together. хөтөлбөр

Women's World Banking  
хамтын ажиллагаа

## ХАСҮ сан



## Ивээн тэтгэлэг

Е-спорт ивээн тэтгэлэг  
(MESA)

Токиогийн паралимпид  
Ардын тамирчид алтан  
медаль хүртэв

Ардын тулаанчид "MFC  
USA"-д ялалт байгуулав

ICT EXPO  
Цахим Үндэстэн 2021



# Хөрөнгө босголт, худалдан авалт

(сая төгрөг)						
(Нэгдлийн хэмжээнд)	ХЭ тоо	Дүн	AARD	AIC	ADB	Бусад
<b>Нийт хөрөнгө босголт</b>		<b>41,417</b>	<b>26,741</b>	<b>5,937</b>	<b>7,761</b>	<b>978</b>
Олон нийтээс	15,560	13,079	9,176	1,244	1,681	978
Стратегийн ХО-с	3	28,338	17,565	4,693	6,080	0
<b>Хувьцаа худалдан авалт</b>		<b>41,029</b>	<b>37,908</b>	<b>1,508</b>	<b>1,614</b>	

(Хувьцааны үлдэгдэл)	2020У4	%	Өөрчлөлт	2021У4	%
<b>Батхишиг Хишигдорж</b>	2,657,214	9.3%	(2,452,339) (8.6%)	204,875	0.7%



# АрдКойн тараалт, худалдан авалт


2021

Урамшуулал	Харилцагч	ARDX (сая)
<b>Нийт олгосон АрдКойн</b>	<b>889,056</b>	<b>83.9</b>
Бүртгэл	348,921	36.0
И-мэйл баталгаажуулалт	117,489	8.8
Найзаа урих	220,259	21.9
Фэйсбүүк баталгаажуулалт	128,852	10.1
АрдКидс	6,327	3.2
Бусад	67,208	3.9
<b>Худалдан авсан АрдКойн</b>		
Тоо хэмжээ (сая)		179
Үнийн дүн		₮30.5 тэрбум

# Үнэлгээ

(сая төгрөг)	Аргачлал	2020У4	2021У4	%
<b>Стратегийн хөрөнгө оруулалт</b>		<b>67,449</b>	<b>385,676</b>	
Монгол Шуудан (MSE: MNP)	MV	17,689	31,727	23.6%
Ард Даатгал (MSE: AIC)	MV	13,108	14,970	45.4%
Ард Кредит (MSE: ADB)	MV	14,080	25,009	40.6%
Ард Секюритиз	BV	2,305	14,239	90.0%
Ард Менежмент	BV	1,265	6,924	90.0%
Ард Актив	BV	99	735	9.4%
Ард Лайф	BV	11,426	33,217	95.0%
Ард Лизинг	BV		10,766	100.0%
ТэнГэр Системс	BV	1,154	10,482	100.0%
Ард Холдингс Интернешнл	BV	6,324	15,002	100.0%
Ард Пропертиз	BV		18,211	100.0%
Ард Бит	MV of ARDX		84,017	100.0%
DAX*	DCF		45,000	60.0%
Даац хөрөнгө оруулалт (54% of	LT		4,096	51.0%
ТэнГэрЛиг Медиа Нэгдэл	MV		57,781	41.8%
ГрэйпСити Монгол	LT		9,000	45.0%
Мост Финтек	LT		4,500	45.0%
<b>Тактикийн хөрөнгө оруулалт</b>		<b>50</b>	<b>15,708</b>	
Үндэсний Хувьчлалын Сан (MSE:	MV	3	19	0.2%
Булган Ундрага (MSE: BUN)	MV	28	5,319	28.5%
Бусад өмч болон бонд		19	10,370	
<b>Бусад</b>		<b>(8,263)</b>	<b>36,085</b>	
Үндсэн болон биет бус хөрөнгө		9,407	62,321	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		101	320	
Бусад цэвэр хөрөнгө		(17,771)	(26,556)	
<b>Нийт үнэлгээ</b>		<b>59,236</b>	<b>437,469</b>	
Эргэлтэд байгаа хувьцааны тоо		27,175,629	28,614,263	
<b>Нэгж хувьцааны үнэлгээ (төгрөг)</b>		<b>2,180</b>	<b>15,288</b>	


■ Стратегийн
 ■ Тактикийн
 ■ Бусад



# Эрсдэлийн удирдлага



Үлгэр жишээ  
**засаглалын**  
ТОГТОЛЦОО



Хамгаалалтын  
**гурван түвшинт**  
ТОГТОЛЦОО

- III хамгаалалтын түвшин** Дотоод аудитор Засаглал, Дотоод хяналтын бүтцэд хараат бус үнэлгээг хийх
- II хамгаалалтын түвшин** Хяналт тавих нэгжүүд Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, хангах, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дэргэдэх хороод мэдээлэх
- I хамгаалалтын түвшин** Группын бүх нэгж, ажилчид Өдөр тутмын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага




# Хөрөнгө оруулалтын багц

# Хөрөнгө оруулалтын багц

## Санхүү

## Платформ



● Ард Санхүүгийн Нэгдэл  
● Холбоотой талууд  
▲ Нээлттэй компани

\* 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар

# Хөрөнгө оруулалтын багц

## Медиа

## Мэдээллийн технологи

## Нийгмийн хариуцлага

Хэвлэл мэдээлэл




41.83%

Контент



66%

ТВ



100%\*

IT



100%

Програм хангамж  
хөгжүүлэлт



45%

ХАГУ сан



ТВ



40%\*

Студио



IT



51%

IT



25%

Ард Академи



100%

- Ард Санхүүгийн Нэгдэл
- Холбоотой талууд
- ▲ Нээлттэй компани







\* 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар

# Ардын компаниуд

#	(сая төгрөг)	Хөрөнгө	Өр төлбөр	Эздийн өмч	Цэвэр ашиг	Нийт дэлгэрэнгүй орлого
1	Ард Санхүүгийн Нэгдэл	332,089	68,732	263,356	1,395	194,518
2	Ард Даатгал	34,038	15,694	18,344	7,124	7,124
3	Ард Кредит	77,917	51,168	26,749	4,193	15,746
4	Ардын Тэтгэврийн Данс	62,137	27,172	34,965	3,929	23,652
5	Ард Актив	30,244	22,394	7,850	406	406
6	Ард Секюритиз	18,071	2,249	15,821	1,635	8,335
7	DAX	261,075	258,436	2,639	3,152	2,026
8	Ард Менежмент	7,645	937	6,708	97	5,111
9	Ард Пропертиз	28,553	10,342	18,211	2,820	17,917
10	Ард Лизинг	32,713	21,948	10,766	5,151	5,151
11	АрдШоп	1,651	2,775	-1,124	-195	-195
12	Ард Холдингс Интернешнл	19,866	4,863	15,002	553	9,704
13	Ард Бит	80,260	53,171	27,089	-2,556	12,663
14	Үндэсний Хувьчлалын Сан	10,160	531	9,628	4,407	4,407
15	ТэнГэр Системс	13,485	3,003	10,482	5,314	5,314
16	И Ай Ти	69,850	14,053	55,797	6,711	6,711
17	Булган Ундрага	14,250	968	13,283	267	8,724
18	Ард Финтек Солюшн	4,922	1,062	3,860	28	28
19	UBX	4,067	3,517	550	-1,350	-1,350
20	ТэнГэрЛиг Медиа Нэгдэл	29,682	5,023	24,659	83	
	<b>Нийт</b>	<b>1,132,673</b>	<b>568,038</b>	<b>564,635</b>	<b>43,164</b>	<b>325,994</b>




# Ардын компаниудын хувьцааны арилжаа - 2021 онд



(Төгрөг)	AARD	AIC	ADB	XOC	BUN	TNGR	MNP	MSE TOP-20
<b>Нээлт</b>	1,699	800	82	100	109	2247	640	19,082.37
<b>52 долоо хоног</b>	1,628 - 12,750	720 - 1,749	77 - 351	107 - 654	875 - 224,300	2,247 - 36,700	875 - 1,903	19,024.52 - 49,252.48
<b>Хаалт</b>	9,785	1,319	220	199	164,900	20,000	1,350	44,411.6
<b>33Ү (тэрбум)</b>	280	33	62	10	19	120	134	
<b>Хувьцааны эргэлт</b>	33%	34%	38%	52%	47%	38%	1%	8.79%
<b>Арилжааны дүн (тэрбум)</b>	72.2	10.5	19.7	6.9	2.9	14.7	1.1	(дундаж)
<b>МХБ эзлэх хувь</b>	33%	4.7%	8.6%	74%*	1.3%	6.4%	0.5%	

(Нийт Ардын хувьцаанууд МХБ хувьцааны хоёрдогч арилжааны 54.5 хувь, ҮХС ХОС хоёрдогч арилжааны 74 хувь)

# Бүтээлч түйвээлт





# Хараат бус аудитын тайлан

# Хараат бус аудитын дүгнэлт



“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК  
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний  
дэлхийн сүлжээний бие даасан фирм

## Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

Далай тауэр 9 давхар, ЮНЕСКО  
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р  
хороо, Улаанбаатар 14230,  
Монгол улс  
Т + 976 70 110744  
+ 976 70 110799

Dalai Tower, 9 fl, UNESCO street,  
Sukhbaatar District-1, Ulaanbaatar  
14230, Mongolia  
Т + 976 70 110744  
+ 976 70 110799

“Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бид “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь “хураангуй санхүүгийн тайлан” гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй болно.

### Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт өгсөн. Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлуудад СТОУС 9 “Санхүүгийн хэрэглүүр”-т өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, Виртуал хөрөнгийн бүртгэл, СТОУС 16 “Түрээс”-тэй холбоотой ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөлт, СТОУС 10 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан”-д заагдсан хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн статусыг хангах тухай зэрэг асуудлуудыг авч үзсэн бөгөөд бид энэ асуудлуудаар дүгнэлтээ хязгаарлаагүй болно.

### Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

### Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын “Аудитын тухай” хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

Б.ОСОРГАВ  
УДИРДАХ ПАРТНЕР  
Монгол улс, Улаанбаатар хот  
2022 оны 3 дугаар сарын 31

“Ард санхүүгийн нэгдэл” ХК  
Хураангуй санхүүгийн тайлан  
2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
<b>Хөрөнгө</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	330,722	100,958
Дансны болон бусад авлага	23,076,380	1,685,343
Бусад санхүүгийн хөрөнгө	10,369,946	18,737
Бараа материал	107,959	2,112
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,708,456	1,243,564
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>37,593,463</b>	<b>3,050,714</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	645,221	466,025
Биет бус хөрөнгө	59,160,237	8,941,367
Ашиглах эрхтэй хөрөнгө	2,349,551	440,433
Урт хугацаат хөрөнгө оруулалт	231,730,778	67,481,313
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>293,885,787</b>	<b>77,329,138</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>331,479,250</b>	<b>80,379,852</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны болон бусад өглөг	28,703,917	4,552,360
Богино хугацаат зээл	10,516,124	1,147,287
Богино хугацаат хаалттай бондын өр төлбөр	3,685,489	11,958,106
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	979,547	349,718
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>43,885,077</b>	<b>18,007,471</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Хойшлогдсон татварын өр	24,188,557	3,405,208
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	1,473,974	379,093
Урт хугацаат зээл	2,300,040	408,752
Урт хугацаат хаалттай бондын өр төлбөр	1,583,000	2,347,232
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>29,545,571</b>	<b>6,540,285</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>73,430,648</b>	<b>24,547,756</b>
<b>Эздийн өмч</b>		
Өмч-хувьцаат	28,614,263	28,590,335
Халаасны хувьцаа	-	(1,414,706)
Нэмж төлөгдсөн капитал	2,927,696	-
Дахин үнэлгээний нөөц	214,347,421	27,284,096
Эздийн өмчийн бусад хэсэг	13,799	13,799
Хуримтлагдсан ашиг	12,145,423	1,358,572
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>258,048,602</b>	<b>55,832,096</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>331,479,250</b>	<b>80,379,852</b>

# Хараат бус аудитын дүгнэлт

“Ард санхүүгийн нэгдэл” ХК  
Хураангуй санхүүгийн тайлан  
2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний орлого	2,030,180	688,461
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз	17,708,213	303,915
Ногдол ашгийн орлого	1,004,162	1,311,736
Хөрөнгө оруулалтын багцын хүүгийн орлого	1,316,383	29,984
<b>Нийт хөрөнгө оруулалтын орлого</b>	<b>22,058,938</b>	<b>2,334,096</b>
Бусад орлого	784,268	916,740
Борлуулалт, маркетингийн зардал	1,095,852	271,381
Ерөнхий ба удирдлагын зардал	16,266,063	3,183,791
Санхүүгийн зардал	3,346,137	2,876,353
Бусад зардал	2,349,625	785,887
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(361)	(170,140)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	(26,955)	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(241,787)</b>	<b>(4,036,716)</b>
Орлогын татварын зардал (өгөөж)	(27,437)	(2,041)
<b>Тайлант үеийн цэвэр алдагдал</b>	<b>(214,350)</b>	<b>(4,034,675)</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
Хөрөнгө оруулалт болон виртуал хөрөнгийн үнэлгээний олз	187,063,325	3,178,618
Хөрөнгө оруулалт болон виртуал хөрөнгөөс хэрэгжсэн олз	11,805,694	1,056,403
<b>Бусад дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>198,869,019</b>	<b>4,235,021</b>
<b>Нийт дэлгэрэнгүй ашиг</b>	<b>198,654,669</b>	<b>200,346</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал</b>	<b>(0.01)</b>	<b>(0.15)</b>

“Ард санхүүгийн нэгдэл” ХК  
Хураангуй санхүүгийн тайлан  
2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 1 сарын 1-ний үлдэгдэл</b>	<b>28,590,335</b>	<b>(1,414,706)</b>	-	<b>24,105,478</b>	<b>13,799</b>	<b>5,287,424</b>	<b>56,582,330</b>
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	-	-	(4,034,675)	(4,034,675)
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	4,235,021	-	-	4,235,021
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	(950,580)	(950,580)
Дахин үнэлгээний нөөцөөс хэрэгжсэн дүн	-	-	-	(1,056,403)	-	1,056,403	-
<b>2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>28,590,335</b>	<b>(1,414,706)</b>	-	<b>27,284,096</b>	<b>13,799</b>	<b>1,358,572</b>	<b>55,832,096</b>
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	-	-	(214,350)	(214,350)
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	198,869,019	-	-	198,869,019
Өмчид гарсан өөрчлөлт	23,928	1,414,706	2,927,696	-	-	(23,928)	4,342,402
Дахин үнэлгээний нөөцөөс хэрэгжсэн дүн	-	-	-	(11,805,694)	-	11,025,129	(780,565)
<b>2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>28,614,263</b>	<b>-</b>	<b>2,927,696</b>	<b>214,347,421</b>	<b>13,799</b>	<b>12,145,423</b>	<b>258,048,602</b>

# Хараат бус аудитын дүгнэлт

“Ард санхүүгийн нэгдэл” ХК  
Хураангуй санхүүгийн тайлан  
2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>2,782,715</b>	<b>417,427</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,782,715	-
Бусад мөнгөн орлого	-	417,427
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>8,302,909</b>	<b>4,928,032</b>
Ажиллагчдад төлсөн	1,487,785	435,619
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	271,633	73,927
Бараа материал худалдан авахад төлсөн	117,682	10,421
Ашиглалтын зардалд төлсөн	52,037	622,131
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	135,533	15,773
Хүүний төлбөрт төлсөн	2,730,145	1,825,104
Татварын байгууллагад төлсөн	1,001,667	119,558
Даатгалын төлбөрт төлсөн	26,755	10,903
Бусад мөнгөн зарлага	2,479,672	1,814,596
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,520,194)</b>	<b>(4,510,605)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>51,176,390</b>	<b>3,272,094</b>
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	10,800,405	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	20,850,000	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	17,665,239	3,197,168
Хүлээн авсан хүүний орлого	957,000	900
Хүлээн авсан ногдол ашиг	903,746	74,026

“Ард санхүүгийн нэгдэл” ХК  
Хураангуй санхүүгийн тайлан  
2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>49,492,446</b>	<b>1,407,956</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	601,044	3,823
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	100,000	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	13,587,474	1,143,667
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	35,203,928	260,466
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,683,944</b>	<b>1,864,138</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>20,768,079</b>	<b>9,922,914</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	20,768,079	3,749,000
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	6,173,914
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>16,702,065</b>	<b>7,218,725</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	16,415,124	2,918,723
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	137,863	224,543
Хувьцаа буцаан худалдаж авхад төлсөн	-	3,768,800
Төлсөн ногдол ашиг	149,078	306,659
Бусад мөнгөн зарлага	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>4,066,014</b>	<b>2,704,189</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>229,764</b>	<b>57,722</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>100,958</b>	<b>43,236</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>330,722</b>	<b>100,958</b>

Тодруулга: “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн энэхүү хураангуй санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан болон орлогын дэлгэрэнгүй тайлангаас ямар нэгэн зөрүүгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.



MSE: **ARD**

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭНД  
**НЭГДСЭНД БАЯРЛАЛАА**

Хүчтэй. Хамтдаа.